

**ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:**

ИНТЕРНЭЙШНЛ МЕДИКАЛ СЕНТЕР ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



/ Я. НИЯМТОГТОХ /

**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 19-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ  
ИНТЕРНЭЙШНЛ МЕДИКАЛ СЕНТЕР ХХК-ИЙН ИНТЕРМЕД ЭМНЭЛЭГ БОЛОН ЭМНЭЛГИЙН  
ӨРГӨТГӨЛИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

УЛААНБААТАР ХОТ

2023 ОН

## АГУУЛГА

1. Оршил
2. Төслийн товч танилцуулга
  - 2.1 Төслийн хэрэгжүүлэгч
  - 2.2 Төслийн товч танилцуулга
3. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт
  - 3.1 Төслийн талбай
  - 3.2 Төсөл хэрэгжих орчны өнөөгийн байгаль орчны төлөв байдал
  - 3.3 Нийгэм-эдийн засгийн байдал
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
  - 4.1 Агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл
  - 4.2 Хөрсөн бүрхэвчийн чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл
  - 4.3 Усан орчины чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл
  - 4.4 Биологийн олон янз байдлын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл
5. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөө
  - 5.1 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
  - 5.2 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
  - 5.3 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
  - 5.4 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө
  - 5.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
  - 5.6 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

## 1.ОРШИЛ

Дэлхийн жишигт хүрсэн чанартай эмнэлгийн тусламж, үйлчилгээг эх нутагтаа бий болгох, гадаад улс орнууд руу оношилгоо, эмчилгээ хийлгэхээр явах иргэдийн урсгалыг сааруулах үйлсэд хувь нэмрээ оруулах зорилгоор үндэсний тэргүүлэх 3 компани болох М-Си-Эс групп, Энержи ресурс ХХК болон Шунхлай групп хамтран өөрсдийн нийгмийн хариуцлагын хүрээнд Интермед эмнэлгийг байгуулж 2014 оны 5 сард үйл ажиллагааг эхлүүлсэн. Интермед эмнэлэг нь 2016 онд дэлхийн 100 гаруй орны эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажилладаг магадлан итгэмжлэлийн Joint Commission International (JCI) байгууллагын магадлан итгэмжлэлийн "Алтан тамга"-ын эзэн болсон бөгөөд 1100 шалгуур үзүүлэлт бүхий бүлэг стандартыг бүрэн биелүүлсэн тул тус байгууллагаас Интермед эмнэлгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Монголын анхны эмнэлэг гэдгийг зарлаж 2016 оны 8 сард итгэмжлэл гардуулсан байна.

Интермед эмнэлэг нь хэвтэн эмчлүүлэх 90 ортой бөгөөд мэс засал, дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн үндсэн тасгууд, нүд, шүд, чих, хамар, хоолой, мэдрэл, дотор, арьс, харшил, уламжлалт, сэргээн засах төрөлжсөн мэргэжлийн кабинетуудтайгаар Хан-Уул дүүргийн 19-р хороонд үйл ажиллагаа явуулж байна.

Интермед эмнэлэг болон эмнэлгийн өргөтгөлийн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хүрээнд төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоож, тэдгээр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээ, болзошгүй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ зэргийг мэргэжлийн байгууллагаар боловсруулан, цаашид Интернэйшнл медикал сентер ХХК-ийн байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөг боловсруулан, холбогдох зардлуудыг тусгав.

## 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1 Төсөл хэрэгжүүлэгч


Төслийн нэр:	Интермед эмнэлэг болон эмнэлгийн өргөтгөлийн төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	1. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Интернэйшнл медикал сентер ХХК 2. Улсын бүртгэлийн дугаар: 9011232136 3. Регистрийн дугаар: 5387051 4. Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороо, Чингисийн өргөн чөлөө 41, Интермед эмнэлэг 4-р давхар 5. Утас: +976 77111108, +976 70000203 6. Цахим хаяг: info@intermed.mn

### 2.2 Төслийн товч танилцуулга

Интермед эмнэлгийн гол зорилго нь анагаах ухааны тэргүүний ололт дэвшлийг эх нутагтаа анхлан нэвтрүүлж, дэлхийн жишигт хүрсэн тусламж үйлчилгээ үзүүлж, үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг бий болгох явдал юм. Тус эмнэлэг нь эмнэлгийн хүчин чадлаа нэмэгдүүлэх зорилгоор одоо байгаа төв эмнэлгийн А блокийн хойно 10 давхар эмнэлгийн барилгыг барьж байгуулахаар мөн Б блокийн зүүн урд 3 давхар автомашины ил зогсоолыг 2022 оны 4-р улиралд ашиглалтанд оруулсан байна.

Интермед төв эмнэлэг нь хэвтэн эмчлүүлэх 90 ортой, жилд дунджаар 5000 хүнд хэвтэн эмчлүүлэх, 200 мянга гаруй хүнд амбулаторийн болон урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээг хүргэх хүчин чадалтай. Мөн 2017 онд эмнэлгийн тусламж үйлчилгээний цар хүрээгээ тэлж Интермед Шангри-Ла клиник, 2018 онд Интермед явуулын клиник, 2020 онд Интермед Сонгинохайрхан клиникийг тус тус нээн амжилттай ажиллаж байна. 2021 онд Интермед Шангри-Ла клиникийн үйл ажиллагаа явуулах байршлыг Сүхбаатар дүүрэгт шилжүүлж тус оноос эхлэн Интермед Сүхбаатар клиник нэртэйгээр үйл ажиллагаа явуулах болсон. Интермед эмнэлэг нь хүчин чадлаа 50-60% нэмэгдүүлж, 8654 хүнд хэвтэн эмчлүүлэх, 20 мянга гаруй хүнд амбулаторийн үзлэг, зөвлөгөө өгөх чадавхтай болохоор барилгын өргөтгөлийн ажлыг 2022 оноос эхлүүлэн ажиллаж байна.

Зураг 1. Өргөтгөлийн барилгын зураг төсөл





### 3. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### 3.1 Төслийн талбай

Интернэйшл медиал сентер ХХК-ийн Интермед эмнэлэг болон эмнэлгийн өргөтгөлийн төслийн талбай нь нийслэлийн Хан-Уул дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэрт 0.8661 га талбайд байрлаж байна. Интермед эмнэлэг нь Хан-Уул дүүргийн үйлдвэрийн бүсэд байрлах бөгөөд төслийн талбайн баруун талд АПУ компани, зүүн урд талд Богд хааны ордон музей тус тус байрлана.

№	Уртраг	Өргөрөг
1	642431.14	5306701.82
2	642427.08	5306721.57
3	642423.92	5306736.98
4	642441.92	5306740.93
5	642453.90	5306743.56
6	642460.79	5306745.08
7	642468.33	5306709.89
8	642425.18	5306730.82
9	642414.90	5306728.84
10	642415.92	5306724.35
11	642387.21	5306724.29
12	642387.13	5306728.82
13	642383.52	5306730.40
14	642379.22	5306808.43
15	642378.75	5306816.58
16	642449.41	5306819.94
17	642453.51	5306743.99
18	642423.92	5306736.98
19	642431.14	5306701.82
20	642461.65	5306708.44
21	642470.09	5306671.04
22	642438.48	5306665.10

Хүснэгт 1. Төслийн талбайн солбилцлын цэгүүд



Зураг 2. Интермед эмнэлэгийн байршил

### 3.2 Төсөл хэрэгжих орчны өнөөгийн байгаль орчны төлөв байдал

**Физик газарзүй.** Интермед төв эмнэлэг нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 19-р хороонд байрлах ба Хан-Уул дүүрэг нь Дархан цаазат Богдхан уулын баруун хойд талд Туул голын хөндийд байрлана. Туул голын хөндий нь зүүнээс баруун тийш 30 орчим км сунасан, өргөн нь 4-5 км, далайн түвшинээс дээш 1250-1300м өргөгдсөн бөгөөд урд талаараа Баянзүрх уул (1843.3м), хойд талаараа Чингэлтэй түүний салбар уулсаар хүрээлэгдэнэ. Төслийн талбай нь Монгол орны физик газар зүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужид хамаарна.

**Уур амьсгал.** Улаанбаатар хот нь уур амьсгалын хувьд хүйтэн өвөлтэй, сэрүүвтэр зунтай, эх газрын эрс тэс уур амьсгалтай, сэрүүн, нэн хүйтэн мужид хамаардаг. Улаанбаатар хотод сүүлийн 40 жилийн агаарын дундаж температур -0.7 С байгаа бөгөөд агаарын температурын сарын явцаас харахад 7 дугаар сар хамгийн дулаан, 1 дүгээр сар хамгийн хүйтэн байдаг байна. Төсөл хэрэгжих нутгийн жилийн дундаж чийгшил 70-75% байдаг бөгөөд хур тунадасны 95-97% нь дулааны улиралд, 75-80% нь зуны улиралд ордог ерөнхий зүй тогтолтой.

**Хөрсөн бүрхэвч.** Төслийн талбайн 90 хувь нь хатуу хучилттай, 10 хувь нь ногоон байгууламж байна.

**Ургамлан нөмрөг.** Төслийн нийт талбайн 10 хувь буюу 900 м<sup>2</sup> талбайд хайлаас, агч зэрэг мод тарьсан.

**Амьтны аймаг.** Интермед төв эмнэлэг нь Хан-Уул дүүргийн үйлдвэрлэлийн бүсэд байрладаг бөгөөд тус бүс нутгийн амьтны аймгийн экосистемийн шинж төрх бүрэн алдагдаж, амьтны зүйлийн бүрдэл нь хот суурин, хүний ойр орчимд амьдардаг синантроп зүйлүүдээс бүрдэх болжээ. Улаанбаатар хотод амьтны аймгаас хамгийн өргөн тархсан цөөн зүйлийн шувуу, шавж, хөхтөн судалгаагаар тодорхойлогдсон байдаг. Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн ба хээрийн бор шувуу, шаазгай, сохор элээ, хөх бор тагтаа, хар элээ, хөхтний дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, гэрийн хулгана, үлийн цагаан оготнууд байна.

**Түүх соёлын өв археологийн дурсгал.** Төслийн талбайд түүх соёлын өв, археологийн дурсгал бүртгэгдээгүй байна. Харин төслийн талбайн зүүн урд Богд хааны ногоон ордны цогцолбор байрлана. Тус цогцолборыг Монгол улсын Засгийн газрын 13 дугаар тоот тогтоолын хавсралтаар "Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал" хэмээн баталсан.

### 3.3 Нийгэм-эдийн засгийн байдал

Интермед төв эмнэлэг нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 19-р хороонд үйлдвэрийн бүсэд байрлах бөгөөд 19-р хороо нь нийт 11032 хүн амтай. Ажиллах хүчний судалгааны дүнгээр 2021 онд Хан-Уул дүүргийн хэмжээнд эдийн засгийн идэвхтэй хүн ам 66815 байгаагаас 89.4 хувь нь ажиллагчид, 10.6 хувь нь ажилгүй иргэд байна. 2019 онд Хан-Уул дүүргийн хэмжээнд нийт 73 эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын 456 их эмч нар иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн байна. Хан-Уул дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2021 оны 5 сард 73 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 13.3 тэрбум төгрөгөөр (15.4%) дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2020 оноос 77.6 хувь өссөн үзүүлэлттэй байна.

#### 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Интермед эмнэлгийн болон эмнэлгийн өргөтгөлийн төслөөс байгаль орчинд нөлөөлж болзошгүй гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг агаарын чанар, хөрсөн бүрхэвч, усан орчин, биологийн олон янз байдал гэсэн байгалийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдэд, эмнэлгийн үйл ажиллагаанаас болон өргөтгөлийн барилгын үйл ажиллагаанаас учрах сөрөг нөлөөллийг байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тодорхойлсон.

##### 4.1 Агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл

№	Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа	Боломжит/Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шалгуур үзүүлэлт			Боломжит нөлөөллийн зэрэглэл
			Үзүүлэлт	Цар хүрээ	Магадлал	
1	Эмнэлгийн үйл ажиллагаа	Интермед эмнэлэгт үйлчлүүлж буй тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулагчид орчны агаарын чанарт нөлөөлөх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Бага	Боломжтой	Бага
2		Өргөтгөлийн барилгын ажлын үед агаарт тоосжилт үүсэх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Богино хугацааны Эрчим: Маш бага	Бага	Болзошгүй	Бага
3	Барилгын ажил	Барилгын ажилд ашиглагдах машин техник, тоног төхөөрөмжөөс утаа, хорт хий ялгарч агаарын чанарт нөлөөлөх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Богино хугацааны Эрчим: Бага	Маш бага	Болзошгүй	Маш бага
4		Барилгын ажилд экскаватор, дугуйт бульдозер, индүү зэрэг том оврын машинуудыг ашиглах ба тэдгээрээс дуу чимээний бохирдол үүсэх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Богино хугацааны Эрчим: Бага	Бага	Боломжтой	Бага

Хүснэгт 2. Агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийн матриц

##### 4.2 Хөрсөн бүрхэвчийн чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл

№	Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа	Боломжит/Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шалгуур үзүүлэлт			Боломжит нөлөөллийн зэрэглэл
			Үзүүлэлт	Цар хүрээ	Магадлал	
1	Химийн бодис ашиглах	Эмнэлэгт ашиглагдах химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу тээвэрлэж хадгалаагүйн улмаас химийн бодис алдагдан хөрсөнд нэвчин хөрсийг бохирдуулж болзошгүй	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Бага	Магадгүй	Маш бага
2	Эмнэлгийн үйл ажиллагаа	Ахуйн болон эмнэлгийн хог хаягдлаар хогийн цэгийн ойр орчмын хатуу хучилтгүй талбайн хөрс бохирдох	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны	Бага	Магадгүй	Маш бага

			<b>Эрчим:</b> Бага			
			<b>Нөлөөллийн хэлбэр:</b> Шууд			
3	Барилгын хог хаягдлаар хөрсөн бүрхэвч бохирдох		Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай	<b>Маш бага</b>	<b>Магадгүй</b>	<b>Маш бага</b>
	Барилгын ажил		<b>Хугацаа:</b> Богино хугацааны			
			<b>Эрчим:</b> Маш бага			
			<b>Нөлөөллийн хэлбэр:</b> Шууд			
4	Машин техникийн аюулгүй байдал алдагдаж тос тосолгооны материал алдагдах, улмаар хөрс бохирдож магадгүй		Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай	<b>Маш бага</b>	<b>Магадгүй</b>	<b>Маш бага</b>
			<b>Хугацаа:</b> Богино хугацааны			
			<b>Эрчим:</b> Маш бага			

Хүснэгт 3. Хөрсөн бүрхэвчийн чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийн матриц

#### 4.3 Усан орчины чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл

№	Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа	Боломжит/Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шалгуур үзүүлэлт			Боломжит нөлөөллийн зэрэглэл	
			Үзүүлэлт	Цар хүрээ	Магадлал		
1	Эмнэлгийн үнд ахуйн усны хэрэглээ	Эмнэлгийн үйл ажиллагааны үед хоногт 104.8 м <sup>3</sup> ус ашиглана.	<b>Нөлөөллийн хэлбэр:</b> Шууд сөрөг	<b>Газарзүйн цар хүрээ:</b> Төслийн талбай	<b>Маш бага</b>	<b>Боломжтой</b>	<b>Бага</b>
			<b>Хугацаа:</b> Урт хугацааны				
			<b>Эрчим:</b> Бага				

Хүснэгт 4. Усан орчины чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийн матриц

#### 4.4 Биологийн олон янз байдлын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл

Интермед төв эмнэлэг нь Хан-Уул дүүргийн үйлдвэрийн бүсэд байрлаж байгаа бөгөөд төслийн үйл ажиллагааны улмаас биологийн олон янз байдал шууд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байна.



## 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан болон үйлдвэрийн талбайд хийсэн шинжилгээний дүн зэргийг үндэслэн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний голлох зорилтуудыг дэвшүүлж байна.

Үүнд:

- Байгаль орчны хамгаалах төлөвлөгөө
- Ногоон байгууламжийн төлөвлөгөө
- Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө
- Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө
- Орчны, хяналтын шинжилгээний хөтөлбөр

Эмнэлэгийн талбай нь үйлдвэрийн бүсэд оршдог, гаднах талбай нь хатуу хучилттай, төвийн цэвэр, бохир ус, дулааны шугамд холбогдсон учир бусад байгалийн бүрэлдэхүүн хэсэгт шууд сөрөг нөлөөлөл үүсгэхээргүй боловч бичил экосистемд үзүүлэх бага хэмжээний нөлөөллийг бүрэн арилгаж ажиллах нь зүйтэй юм.

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	5.600.000
2	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	500.000
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1.000.000
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2.000.000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	800.000
<b>Нийт зардал</b>		<b>9.900.000</b>

Хүснэгт 5. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

**5.1 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Барилгын ажилд ашиглагдах машин техник, тоног төхөөрөмжөөс угаа, хорт хий ялгарч агаарын чанарт нөлөөлөх	2 Барилгын ажилд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэгт, засвар үйлчилгээнд хамруулсан эсэхэд хяналт тавих	3 Төслийн талбай	4 ш	5 -	6 30	7 Үйл ажиллагааны зардалд тусгах	8 Улиралд 1-2 удаа	9 MNS 5885:2008 "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага"
2	Барилгын ажилд эксковатор, дугуйт бульдозер, индүү зэрэг том оврын машинуудыг ашиглах ба тэдгээрээс дуу чимээний бохирдол үүсэх	Одоогийн төв эмнэлэг болон барилгын талбай хооронд тусгаарлагч хаалт хийх	Барилгын талбай	m2	Барилгын хөрөнгө оруулалтын зардалд оруулах	Барилгын хөрөнгө оруулалтын зардалд оруулах	Барилгын ажил эхэлхээс өмнө	MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"	
3	Эмнэлэгт ашиглагдах химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу тээвэрлэж хадгалаагүйн улмаас химийн бодис алдагдан хөрсөнд нэвчин хөрсийг бохирдуулж болзошгүй	Химийн бодисыг зориулалтын саванд хадгалах, лабораторын агааржуулалт тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн ажиллагааг байнга анхаарч, засвар үйлчилгээ, болзошгүй	Төслийн талбай	Бүх химийн бодис	3,000,000	Жилийн турш	MNS 3297:2019 "Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм"		

Нийслэлийн хан-уул дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэрт орших Интернэйшнл медикал сентер ххк-ийн Интермед эмнэлэг болон эмнэлгийн өргөтгөлийн төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4	Ахуйн болон эмнэлэгийн хог хаягдлаар хогийн цэгийн ойр орчмын хатуу хучилтгүй талбайн хөрс бохирдох	Шинэчлэлийг тухай бүр хийх Хогийн цэгийн ойр орчмыг хатуу хучилттай болгох	Хог хаягдал түр хадгалах байр	м2	80.000	25	2.000.000	Барилгын үйл ажиллагааны үед	MNS 5850:2019 "Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ"
5	Машин техникийн аюулгүй байдал алдагдаж тос тосолгооны материал алдагдах, улмаар хөрс бохирдох	Шатах тослох материал тэвэрлэх, хадгалах горимыг дагаж мөрдөх, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг барилгын талбайд бэлэн байлгах	Барилгын талбай	ш	300.000	2	600.000	Жилийн турш	
<b>Нийт</b>									<b>5.600.000 төгрөг</b>

Нийслэлийн хан-уул дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэрт орших Интернэйшнл медикал сентер ххк-ийн Интермед эмнэлэг болон эмнэлгийн өргөтгөлийн төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5.2. НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ									
№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа, тордлогоо хийх	Услах, арчлах	3	4	5	6	7	8	9
			Интермед эмнэлгийн талбай	л	40	500.000		Мод ургалтын хугацаанд 9-р сар хүртэл 8-9 удаа	
<b>Нийт</b>								<b>500.000 төгрөг</b>	

**5.3 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Газар хөдлөл	Дүүргээс зохион байгуулах газар хөдлөлийн аюулын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр болон турших дасгал сургуулилтад ажилчдыг хамруулах	Ажилчид	500	-	-	Жилд 1 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль
2.	Халдварт өвчин	Хоолны газрын эрүүл ахуйг сахиулах	Эмнэлэгийн гал тогоо	-	-	-	Жилийн турш	
3.	Автомашинны осол	Барилгын ажилд ашиглагдах том оврын машины аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдүүлж ажиллах	Барилгын талбай	-	-	-	Жилийн турш	
4.	Химийн бодис асгарах	Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, саармагжуулах асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах / элс, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, хүрз, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг/	Химийн бодис ашиглаж буй бүх тасаг	1	1.000.000	1.000.000	Жилийн турш иж бүрдлийн хэвийн ажиллагааг хянах	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
<b>Нийт</b>							<b>1.000.000 төгрөг</b>	

Нийслэлийн хан-уул дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэрт орших Интернэйшлл медикал сентер ххк-ийн Интермед эмнэлэг болон эмнэлгийн ергөтгөлийн төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

#### 5.4 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	1	2	3	4	5	6	7	8	9
		Хүнсний хог хаягдлыг бордооны болон малын тэжээлийн үйлдвэрт нийлүүлэх	Эмнэлэгийн гал тогоо	удаа				Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
		Бусад хог хаягдлаас дахиварыг ялгаж гэрээт ААН-р үргэлжлүүлэн тээвэрлүүлэх	Интермед эмнэлэг	удаа				Жилийн турш	Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам
		Эмнэлэгийн талбайн ойр орчмын 50 м зайд цэвэрлэгээ хийх	Интермед эмнэлэгийн ойр орчим	удаа		2.000.000		Жилд 1-2 удаа	
	Эмнэлгийн хог хаягдал	Эмнэлгийн хог хаягдлыг ялгаж үргэлжлүүлэн гэрээт компанид нийлүүлэх	Интермед эмнэлэг	удаа				Жилийн турш	Эрүүл мэндийн сайдын А/505 дугаар тушаал
	Барилгын хог хаягдал	Барилгын хог хаягдал тээвэрлэх, устгах зөвшөөрөл бүхий ААН-тэй гэрээ хийн нийлүүлэх	Барилгын талбай	удаа				Жилийн турш	Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах тухай журам
<b>Нийт</b>								<b>2.000.000 төгрөг</b>	

**5.5. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	<ul style="list-style-type: none"> <li>Агаарын чанар</li> <li>Орчны тоосжилт</li> <li>Агаар бохирдуулагч хий</li> <li>Агаарын температур</li> <li>Харьцангуй чийг</li> <li>Гадаад болон дотоод орчны дуу чимээ</li> </ul>	Барилгын талбай	1	Хагас жилд 1 удаа	250.000	500.000	MNS 4585:2017 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
2.	<ul style="list-style-type: none"> <li>Хөрсний хими болон физик</li> <li>Ялзмаг</li> <li>Урвалын орчин</li> <li>Карбонат, нитрат, фосфор, кали</li> <li>Давсжилт</li> <li>Механик бүрэлдэхүүн</li> <li>Эзэлхүүн, жин</li> </ul>	Ногоон байгууламжийн талбай	1	Жилд 1 удаа	200.000	200.000	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох (MNS 3310:91) Хөрс бохирдуулагч бодис, Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 5850:2008)
3.	<ul style="list-style-type: none"> <li>Усан орчин</li> <li>Ерөнхий хими физикийн шинжилгээ</li> <li>Урвалын орчин</li> <li>Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч болон химийн хэрэгцээт хүчилтөрөгч</li> </ul>	Эмнэлгийн унд, ахуйн ус	1	Жилд 1 удаа	100.000	100.000	MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 6778 : 2019 Ундны ус. Хатуулаг тодорхойлох арга
<b>Нийт</b>							<b>800.000 төгрөг</b>

### 5.6 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Нийт зардал, төг
1.	Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авах	2023 ондоо багтаан бэлтгэл ажлыг хангах	Үйл ажиллагааны зардалд тусгах
2.	Байгаль орчныг хамгаалах хуулийн 31.6-д заасны дагуу Экологийн паспорт хөтлөх. MNS 4219:1994 Байгаль орчны хамгаалал. Аж ахуйн нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм стандартын дагуу Экологийн паспорт хөтлөх	2023 ондоо багтаан бэлтгэл ажлыг хангах	Үйл ажиллагааны зардалд тусгах

### 6. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар	2	3	4	6	7
1	Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар	БОМТ-ний хэрэгжилтийн тайлангийн эх хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	11 дүгээр сарын 01-ээс өмнө	Удирдлага	Хан-Уул дүүрэг
3	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	БОМТ-ний хэрэгжилтийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган хүргүүлнэ.		12 дугаар сарын 31-ний дотор		Улаанбаатар хот